

Улсын болон хувийн лабораторийн өнөөгийн байдлын харьцуулалт

Ц.Энхжаргал¹, О.Азжая², С.Чимидцэрэн³

¹Монголын эрүүл мэндийн лабораторийн ажилчдын холбоо

²Нийслэлийн эрүүл мэндийн газар

³Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Үндэслэл

Эрүүл мэндийн лабораторийн тусламж үйлчилгээ нь эрүүл мэндийн системийн чухал хэсэг бөгөөд зохистой бодлого стратегийн хүрээнд шинэ арга техникүүдийг боловсруулан нутагшуулж онош зүйн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэхэд чиглэгдэнэ.

Сүүлийн арваад жил манай орны эрүүл мэндийн үйлчилгээний салбарт хувийн лабораториудийн оролцоо эрс нэмэгдсэн билээ. Гэвч одоогийн байдлаар үйлчлүүлэгчдийн ихэнх нь улсын эмнэлгийн лабораториудаар үйлчлүүлсээр байна.

Лабораторийн үйл ажиллагааны өнөөгийн байдлыг судлан үнэлж эрүүл мэндийн байгууллагын лабораторийн давуу болон сул тал, дутагдлыг бодитойгоор тодорхойлсноор лабораторийн тогтолцоог хөгжүүлэх, бэхжүүлэх, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдэх чухал ач холбогдолтой.

Зорилго

Бид уг судалгаагаар хувийн хэвшлийн болон улсын эмнэлгийн лабораториудын байдлын үнэлгээ хийж, харьцуулан дүгнэх зорилго тавсан юм.

Материал, арга зүй

Судалгаанд ISO 15189 [1]-д үндэслэн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас боловсруулсан лабораторийн үнэлгээний асуумж программыг [2] ашиглан лабораториудын 2018 оны чадавхийн үнэлгээг хийж гүйцэтгэв. Уг үнэлгээнд хувийн хэвшлийн 7, Улаанбаатар хотын дүүргийн нэгдсэн эмнэлэг болон эрүүл мэндийн төвийн 5 лаборатори, нийслэлийн 2 амаржих газрын лаборатори, улсын нийт 7 лабораторийг хамруулав.

Үнэлгээний мэдээллийн боловсруулалтыг Excel LAT программыг ашиглан гүйцэтгэсэн ба асуумжийн багц бүрийг 100 хүртэл оноогоор үнэлэв. Үнэлгээний үзүүлэлтүүдийн харьцуулалтыг t-test ашиглан дүгнэсэн болно.

Үр дүн

Судалгаанд оролцсон хувийн болон улсын нийт 14 лабораторийн чадавхийн үнэлгээний үзүүлэлтийг 11 багц болгон нэгтгэж, харьцуулсан дүнг 1-р хүснэгтэнд тусгав.

Хүснэгт 1. Лабораториудын үнэлгээ ба харьцуулалтын дүн

№	Үзүүлэлтийн багц	Хувийн /оноо/	Улсын /оноо/	p утга
1	Зохион байгуулалт	69	64	0.406
2	Баримт бичиг	70	77	0.364
3	Дээж авах, харьцах, хадгалах	80	88	0.138
4	Мэдээллийн зохицуулалт	85	83	0.715
5	Оношлуур, хэрэгсэл	86	91	0.261
6	Тоног төхөөрөмж	82	92	0.025
7	Шинжилгээний гүйцэтгэл	77	91	0.006
8	Байр	65	74	0.281
9	Хүний нөөц	81	79	0.601
10	Аюулгүй ажиллагаа	51	64	0.092
11	Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ	46	63	0.079
	Дундаж	72	79	0.115

Үзүүлэлтийн 11 багцын нийт дундаж оноог харьцуулахад улсын болон хувийн лабораторийн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй (хувийн 72 ба улсын 79, $p=0.115$).

Улсын лабораториуд 3 багц (Зохион байгуулалт, Мэдээллийн зохицуулалт ба Хүний нөөц)-аас бусад чиглэлээр хувийн хэвшлийн лабораториос илүү үнэлгээтэй байна.

Үнэлгээний оноо нь статистик ач холбогдол бүхий ялгаатай багц Тоног төхөөрөмж (хувийн 82 ба улсын 92, $p=0.025$) ба Шинжилгээний гүйцэтгэл (хувийн 77 ба улсын 91, $p=0.006$) байгаа нь улсын эрүүл мэндийн байгууллага

тоног төхөөрөмжийн тооллого, хяналт хийх олон жилийн тогтсон тогтолцоотой, байгууллагын тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хариуцсан албатай байдагтай холбоотой. Шинжилгээний гүйцэтгэлийн хувьд ажиглагдсан ялгааны шалтгаан нь улсын эрүүл мэндийн байгууллагын ихэнх лабораториудын шинжилгээний багц нь шинжилгээний бүх чиглэлийг хамруулдаг бол хувийн лабораториуд шинжилгээний тодорхой хэдэн чиглэлээр дагнасан байдаг байж болох юм.

Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний багцын асуултууд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын тохиолдолд авах арга хэмжээний талаар байсан тул улсын эрүүл мэндийн байгууллагын лаборатори хувийн лабораториос өндөр оноотой (хувийн 46 ба улсын 63) байна. Гэвч уг чиглэлийн лабораториудын үзүүлэлтүүдийг t-test ашиглан шалгахад ялгаа нь статистик ач хобогдол бүхий байсангүй ($p=0.079$).

Дүгнэлт

Хувийн хэвшлийн болон улсын эрүүл мэндийн байгууллагын лабораториудын үйл ажиллагааны дундаж үнэлгээ их ялгаагүй боловч хувийн лабораториуд тогтмол гүйцэтгэдэг баримт бичгийн хөтлөлт, тоног төхөөрөмжийн үйлчилгээ, аюулгүй ажиллагаа зэрэг үйл ажиллагаагаа сайжруулах шаардлагатай байна.

Ном зүй

1. MNS ISO 15189:2015 Эмнэлгийн лаборатори-Чанар ба чадавхид тавигдах шаардлага
2. Laboratory Assessment Tool. World Health Organization. 2012

Comparison of Current Status of Public and Private Laboratory

Ts.Enkhjargal¹, O.Azzaya², S.Chimedtseren³

¹Mongolian Association of Health Laboratorians

²Metropolitan Health Department

³First State Central Hospital

Background: The past decade has seen an increasing involvement of private for-profit medical laboratories in the national healthcare provision. But the majority of patients still use services of public hospital laboratories.

Goal: The goal of the survey was to assess the status of private and public medical laboratories based on ISO 15189 requirements.

Methods: The overall capacity of seven private and seven public laboratories was assessed using a questionnaire based on ten main requirements of ISO 15189.

Results: In general, the public laboratories scored better than the private laboratories but

the difference was not significant (79 points for public laboratories vs. 72 points for private laboratories; $p=0.115$). The main differences were in the areas of equipment management (82 points for private vs. 92 points for public; $p=0.025$) and testing performances (77 points for private vs. 91 points for public; $p=0.006$). Out of the remaining eight assessment sections, the private laboratories scored better, but not significantly, in the areas of laboratory management and laboratory information system.

*Танилцаж санал өгсөн АУ-ны доктор
В.ХАДХҮҮ*